

Бармуд Улаанхүүгийн “Тэнгэр сүлд товруу” романд илэрсэн үндэсний соёлын үнэт зүйл

Эрдэнэбилиг (Вэн Хуй) 

Хөлөнбуйр дээд сургууль, Хөлөнбуйр, Бүгд Найрамдах Хятад Ард Улс
✉ 13847056740@163.com

Хураангуй: Уран зохиол бол үндэстний уламжлалт соёлыг элбэг баян тусгадаг хэлний урлаг билээ. Уран зохиолын бүтээлээр дамжин тус үндэстний шүтлэг бишрэл, түүх соёл, үнэт зүйл зэргийг бүх талаар ойлгож болно. Роман нь уран зохиолын төрлүүд дотор хуудас хэмжээгээр хамгийн их, дүр, үйл явдал хамгийн нарийн будилаантайн хувьд соёлын илэрхийлэл ч үлэмж баялаг байх нь гарцаагүй бөгөөд эл өгүүлэлд ӨМӨЗО-ы Алшаа нутгийн зохиолч Бармуд Улаанхүүгийн “Тэнгэр сүлд товруу” романы гүнд агуулагдаж байгаа соёлын илэрхийллүүдээр дамжигдан чухам ямар үнэт зүйлс илэрснийг тодруулахыг зорив.

“Тэнгэр сүлд товруу” роман нь Алшаа нутагт хэдэн зуун жил яригдсаар ирсэн бөх Шалбингаар гол баатар болгож, түүний нэг насны амьдралыг урлан бүтээхдээ Алшаа монголчуудын биет бус соёлын өвийн олон илэрхийллийг өргөн дэлгэр багтааснаараа “соёлын нэвтэрхий толь”-ийн үүрэгтэй зохиол болжээ. Иймээс соёлын эдгээр илэрхийллийг эмхлэн харахын тулд Гийрт Хофстедийн “Соёлын давхраат загвар”-ын онолд үндэслэн задлан шинжилгээ хийв. Ийнхүү задлан шинжилснээр хүч чадал, сүсэг бишрэл, эх хэл, мэдлэг ухаан хэмээх дөрвөн төрлийн үнэт зүйлс илэрч буйг харж болох юм. Эдгээр үнэт зүйл нь Алшаа хошууд монголчуудын олон зуун жилийн турш хамгаалан тэмцэж ирсэн өв соёлын хүрээ царгаа бөгөөд “Тэнгэр сүлд товруу” роман нь эдгээрийг цаашид өвлөн уламжлуулахад үнэтэй хувь нэмэр оруулж буй бүтээл болох нь маргаангүй юм хэмээн дүгнэв.

Түлхүүр үгс: үндэсний соёл, үнэт зүйлс, соёлын давхраат загвар, зан үйл, баатар, бэлгэдэл, үйлдэл

The National cultural values reflected in the novel “Tenger Süld Tovruu” by writer Barmud Ulaankhuu

Erdenebilig (Wen Hui) 

Hulunbuir University, Hulunbuir, People's Republic of China

✉13847056740@163.com

Abstract: Literature, as an art form, serves as a reflection of a nation's traditions, culture, and values. Through literary works, one can gain insight into a society's history, beliefs, and way of life. Among various literary genres, the novel stands out for its depth and complexity, making it a rich medium for cultural expression.

This article explores the cultural representations in *Tenger Süld Tovruu*, a novel by Barmud Ulaankhuu, a writer from the Alshaa region of Inner Mongolia. The novel serves as a “cultural encyclopedia,” chronicling the life of Shalbin, a legendary wrestler whose story has been passed down for centuries. By vividly portraying his life, the novel encapsulates the intangible cultural heritage of the Alshaa Mongols. To analyze these cultural expressions, the study applies Geert Hofstede's “Cultural Dimensions Theory.” When analyzed through the framework of the “cultural layered model”, the narrative reveals the presence of three fundamental cultural components - symbols, heroes, and rituals - which give rise to four key values: power, faith, native language, and knowledge. These values encapsulate the cultural legacy that the Alshaa Khoshuud have preserved and defended for generations. In this context, “*Tenger Süld Tovruu*” serves as a meaningful contribution to the safeguarding and transmission of this heritage.

Keywords: “*Tenger Süld Tovruu*” novel, national culture, values, cultural dimensions theory, rituals, heroes, symbols, practices

Оршил

Зохиолч Бармуд Улаанхүүгийн 2007 онд анх хэвлүүлсэн “Тэнгэр сүлд товруу” роман бол Алшаагийн нэрт бөх Шалбингийн домгоос сэдэвлэж туурвисан, “Хөх судар”-ын дараах 100 түмэн үсэгтэй том роман болно” (Алтан-Уул 2021, 99). Тус роман нь монгол соёлын өвийг олон талаар тусгаснаараа онцгойрч, уншигчдын таашаалд нийцсэн төдийгүй Бүгд Найрамдах Хятад Ард Улсын монгол хэлээр бичсэн шилдэг уран зохиолыг хоёр жил тутамд нэг удаа шалгаруулдаг уран зохиолын шагнал, дэмжих хөдөлгөөн хэмээн нэрлэж болох “Боржгин” шагналыг 2009 онд хүртсэн нөлөө бүхий шилдэг бүтээл юм. Улаанхүү малчин гаралтай гэр бүлд 1952 онд төрж, бага нас нь малын бэлчээрт өнгөрч, эцэг Зодовын яриа, домог, ардын үлгэрээс суралцан өвлөсөн нь түүний зохиол бүтээлийн үндэс суурь болжээ. Улаанхүүгийн эцэг нь ёстой “үг хэлний дархан гэмээр хэл хэллэг, зан заншил, ёс жаягтай, хэв намба, аж амьдрал аль ч талаараа дуурайл болсон, хүүхэд ахуй цагаас хүн болохын ёсыг ухааруулсан амьд толь байжээ” (Бармуд Улаанхүү 2024).

Уран зохиол нь нийгэм, соёлын хүчин зүйлээс гарцаагүй хамааралтай буюу орон зай, цаг хугацааг илтгэсэн хам сэдвийн орчинд бүтэж бүрэлддэг. Тиймээс уран зохиол бол зөвхөн зохиолчийн хувь хүний уран сэтгэмжийн илэрхийлэл


төдий бус, тухайн үеийн нийгмийн байдал, соёлын үзэл санаа, улс төрийн нөхцөл байдлыг шингээсэн толь юм. “Тэнгэр сүлд товруу” романыг бичихэд зохиолчийн хувь хүний өсөлт, бойжилт, гэр бүлийн орчин, боловсрол, соёлын мэдлэг чухал үүрэгтэй ч түүхэн цаг үеийн улс төр, нийгэм, соёлын томоохон өөрчлөлтүүдийг орхигдуулж болохгүй. “Соёлын их хувьсгал” (1966-1976) нь урлаг, уран зохиолын салбарт ноцтой хязгаарлалт, боомилт учруулж, олон зохиолч, сэтгэгчдийн үзэл санааг дарамталсан үе байлаа. 1978 оноос хойш “Шинэ эрин” эхэлж, уран зохиол чөлөөтэй хөгжих боломж бүрдэв. Энэ нь өвөр монголын хүүрнэл зохиолын үндэстний ухамсар, соёлын эрэл хайгуулын эрин болж, “Шарх сорвийн утга зохиол”, “Бодлогошролын утга зохиол”, “Нутаг усны утга зохиол” гэх мэт шинэ урсгалуудыг бий болгож, XXI зуун болоход үндэстний түүх ба соёлын хүүрнэлийг нэгтгэсэн *“соёллог хүүрнэл зохиол”* үргэлжлэн хөгжсөн байна. Энэ нөхцөл байдалд Алшаа нутгийн түүх, үлгэр домгууд нь тухайн бүс нутгийн соёлын өвийг судлах, хадгалах, хүүрнэл зохиол болгон хөгжүүлэх үндсэн нөхцөл болж өгчээ. Ийнхүү, бөх Шалбингийн домог нь орон нутгийнхаа үндэстний соёлын өвийг илэрхийлэх нэгэн гол эх сурвалж болж, романы тулгуур сэдэв болжээ. Иймээс “Тэнгэр сүлд товруу” роман нь нийгэм, улс төрийн өөрчлөлт, газар нутгийн түүх соёлоос хүчтэй хамааралтайгаар төрсөн бүтээл билээ.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааны үндсэн эх хэрэглэгдэхүүнээр Алшаагийн зохиолч Бармуд Улаанхүүгийн “Тэнгэр сүлд товруу” романы 2 дахь хэвлэл буюу 2017 оны хэвлэлийг авч ашиглав. Судалгааны зорилгыг биелүүлэхийн тулд *задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тайлан тайлбарлах* аргуудыг хэрэглэв. Онолын хувьд Гийрт Хофстедийн “Соёлын давхраат загвар”-ын онол нь “Тэнгэр сүлд товруу” романы соёлын агуулгыг шинжлэхэд тохиромжтой гэж бид үзэж байна. Учир нь онолын энэхүү загвар роман дахь соёлын нөлөө, харагдахуйц бэлгэдэл, дүрүүдээр дамжин гүн гүнзгий дэх үнэт зүйлс рүү хүргэх боломжийг олгох юм. “Соёлын давхраат загвар”-ын гол зорилго нь соёлын үндсэн үнэт зүйлсийг илрүүлэх явдал учраас “Тэнгэр сүлд товруу” романд шингэсэн утга санааны баялаг давхаргыг нээж, түүний соёлын ач холбогдлыг илүү гүнзгий ойлгож үнэлэх боломжтой болно.

Судалгааны үр дүн

Нидерландын нэрт эрдэмтэн Гийрт Хофстед (Geert Hofstede)-ийн дэвшүүлсэн “Сонгинын загвар” буюу “Соёлын давхраат загвар”-ын онол нь соёлыг сонгино мэт олон давхаргатай бүтэц гэж үздэг бөгөөд эл давхаргаар нь задлан шинжлэх боломжтой гэж тайлбарладаг. Тухайлбал, “Соёлын ялгаа нь олон янзаар илэрдэг. Соёлын илрэх хэлбэрийг тодорхойлох олон нэр томъёоноос дараах дөрвөн үг нь соёлын ерөнхий ойлголтыг товч бөгөөд тодорхой илэрхийлдэг. Үүнд, *бэлгэдэл, баатар, зан үйл, үнэт зүйл* гэсэн соёлын давхаргыг өнгөн талаас нь гүнд хүртэлх бүх давхаргыг илэрхийлэх боломжтой үгс орно. Эдгээрийг сонгинын хэд хэдэн давхарга мэт дүрсэлсэн бөгөөд бэлгэдэл нь гадна давхаргыг, үнэт зүйл нь соёлын хамгийн гүн давхаргыг илэрхийлдэг ба баатар, зан үйл нь тэдгээрийн хооронд оршино.



Зураг 1. Гийрт Хофстедийн боловсруулсан “Соёлын давхраат загвар”

Бэлгэдэл гэдэг нь тодорхой утгатай үг, дохио зангаа, зураг, эд зүйлсийг хэлэх бөгөөд тухайн соёлын хүрээнд буй хүмүүс л эдгээрийн утгыг ойлгодог. Үг хэл болон мэргэжлийн хэллэг нь бэлгэдлийн нэг төрөл бөгөөд хувцаслалт, үсний засалт, далбаа, нийгмийн байр суурийг илэрхийлэгч зүйлс мөн үүнд хамаарна. Шинэ бэлгэдэл амархан үүсдэг бөгөөд хуучин нь цаг хугацааны явцад алга болдог. Нэг бүлгийн соёлын бэлгэдлийг бусад бүлгүүд дуурайх нь түгээмэл. Тиймээс энэ нь бэлгэдлийг хамгийн гадна давхаргад байрлуулах шалтгаан юм.

Баатар гэдэг нь амьд, эсвэл нас барсан ч, ер нь бодит ч, домгийн ч бай тухайн соёлд өндөр үнэлэгдсэн шинж чанарыг агуулсан хүмүүсийг хэлнэ. Тиймээс эдгээр хүмүүс бусдын хувьд үлгэр дуурайл болдог. Америкийн Барби хүүхэлдэй, Бэтмэн, Снүүпи болон францын Астерикс зэрэг нь соёлын баатруудын жишээ юм. Орчин үеийн телевизийн эрин үед баатруудыг сонгохдоо тэдний гадаад төрх илүү чухал болж байна.

Зан үйл нь техникийн хувьд тодорхой зорилгод шууд хүрэхэд зайлшгүй шаардлагатай биш боловч соёлын хувьд нийгэмд заавал байх учиртай хамтын үйл ажиллагааг хэлнэ. Ёслол оршин тогтнох тодорхой шалтгаантай. Үүнд мэндчилэх хэв маяг, хүндэтгэл илэрхийлэх арга барил, олон нийтийн болон шашны баяр ёслолууд хамаарна.


Бэлгэдэл, баатар, зан үйл нь үйлдлүүд гэсэн ойлголтын дор нэгтгэгддэг. Учир нь эдгээр нь гаднын ажиглагчдад харагддаг. Гэвч тэдгээрийн соёлын утга нь шууд харагдахгүй бөгөөд зөвхөн тухайн соёлын гишүүд эдгээр үйлдлүүдээр дамжуулан ойлгож, тайлбарлаж чаддаг. Загварт дурдсанаар соёлын цөм нь **ҮНЭТ ЗҮЙЛЭЭС** бүрддэг. **Үнэлэмж** гэдэг нь аливаа зүйлийн нэг төлөв байдлыг бусад төлөв байдлаас илүүд үзэх өргөн цар хүрээтэй хандлага юм. Үнэлэмж нь эерэг болон сөрөг мэдрэмжийг агуулдаг. Тэр нь чиглэлт сэтгэл хөдлөл юм (霍夫斯泰德, Hofstede 2019, 5). Англи хэлний “Value” буюу “үнэлэмж/ үнэт зүйл” хэмээх ойлголт маш өргөн утгатай бөгөөд үүнийг нэлээд эрт үеэс өрнөдийн философид судалж

ирсэн байдаг. Үнэлэмжийн тухай XIX зуунаас л философид тусгайлан судалж эхэлсэн байна. Харин XX зуунаас эхлэн философийн ухаанаас гадна эдийн засаг, сэтгэл судлал, социологи, антропологийн салбаруудад нэлээд сонирхон судалсан байна. Эдгээр салбаруудын судалгааны арга зүй, чиг баримжаанаас хамаарч тухайн үнэт зүйл, үнэлэмжийг янз бүрийн өнцгөөс, янз бүрийн утгаар авч үзсэн байдаг (Гомбосүрэн 2008, 355-366). Тэдгээрээс бидний энэхүү судалгаатай нарийн холбоотой гэж үзэж болох нь “cultural value” буюу “соёлын үнэт зүйл” юм.

“Тэнгэр сүлд товруу” романы бэлгэдэл, баатар, зан үйл гэсэн гадна давхаргыг үнэт зүйлстэй холбон авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1. “Тэнгэр сүлд товруу” романы үнэт зүйлсийн илэрхийллүүд

	Үнэт зүйлс	Зан үйл	Баатрууд	Бэлгэдлүүд
1	Хүч чадал	Бөхийн барилдаан	- Шалбин - Тогос	- Тоо хэмжээ - Бие цогцос
2	Сүсэг бишрэл	- Цээр ёс - Тахилга - Мэргэ төлгө - Бэлэвсрэлийн ёс	- Хоролой ноён - Мягдар - Балуд өвгөн - Шалбин	- Газар нутаг - Мал сүрэг - Тоо хэмжээ
3	Эх хэл	- Үгсийн сан - Зүйр цэцэн үг - Ерөөл, магтаал - Ардын дуу	- Шалбин - Намхай - Гилдүү - Мягдар	- Мал сүрэг - Тоо хэмжээ - Орон сууц - Газар нутаг
4	Мэдлэг Ухаан	- Хүлэг шинжих, арчлах, уралдах - Шатар тоглох	- Ядам өвгөн - Араантив өвгөн - Шалбин - Хоролой ноён - Мэргэд ба Тонтой	- Мал сүрэг



Зураг 2. Гийрт Хофстедийн боловсруулсан “Соёлын давхраат загвар”-аар “Тэнгэр сүлд товруу” романы үнэт зүйлсийг илрүүлсэн нь

Дээрх бүдүүвч зурагт буй “Тэнгэр сүлд товруу” романаас илэрсэн 4 зүйл үнэт зүйлийг тус бүрээр тодруулан авч үзье.

Хүч чадал. “Тэнгэр сүлд товруу” роман бол бөхийн домгоос сэдэвлэж туурвисан бүтээл. Зохиолч романы гол дүр бөх Шалбингийн олон удаагийн барилдааныг хүүрнэхдээ Алшаа монголчуудын тоо хэмжээ, бие цогцсын бэлгэдлийн соёлыг өргөн дүрсэлж, мөн зодог бөх ба газар нутгийн онцлогтой шалбуур бөхийн зан үйлүүдийг бүх талаар илэрхийлжээ. Роман дахь Шалбин ба түүний эхнэр Тогосын бөхтэй холбогдох тооны бэлгэдлийн хүүрнэлээс жишээлбэл, “Биеэ эр гэж бодоод зодогт минь горилсон бол гурав барилдъя. Зодог шалбуурын аль нь ч болно, намайг нэг удаа сөхрөөж чадвал энэ зодог чинийх болтугай гээд Шалбин нь малгайгаа авлаа” (Улаанхүү 2017, 654); “Чин журмаар эр нөхрөө аварсан Шалбингийн эхнэр Тогосыг “журамт эхнэр” хэмээн цол шагнаж, нийт олны дуурайл болгохын тулд өсвөрийн есөн цагаан тэмээгээр шагнасугай” (Улаанхүү 2017, 774).

Романд Шалбингийн дүрээр хүмүүний эрүүл, хүчирхэг бие цогцсыг харуулсан бөгөөд монгол бөхийн хөрөг бэлгэдлийг илэрхийлсэн “*Арьсан тулмаар тоглож өсөх*”, “*Гэр болон эхээ үүрч нүүх*”, “*Хүүр ясанд нь чоно зулзагалах*” зэрэг өгүүлэмжүүдийн гүн давхаргыг задлан шинжвэл, тэнгэр сүлд товруут зодгийн жинхэнэ эзэн нь “Тэнгэр сүлд товруу” романы соёлын давхаргын цөмд байгаа хүч чадлын үнэт зүйл болно.

Сүсэг бишрэл. “Тэнгэр сүлд товруу” романд монголчуудын сүсэг бишрэл (шашны)-ийн үнэт зүйл олон төрлийн зан үйлээр илэрхийлжээ.

Цээр ёс: Романд Шалбингийн ээж Мягдарын үгээр Алшаа монголчуудын мал сүрэгтэй холбогдох цээр ёсыг тусгажээ. Тухайлбал, “Буур гэгч таван хошуу малын онгон хийморь, өсөх сүргийн дархан сүлд болохоор эзэн болох бурхан сахиус нь хөлгөлж байдаг юм. Иймээс эхнэр хүн хэзээ ч гэсэн унаж зайдлах ёсгүй” (Улаанхүү 2017, 409). Эцэг мал нь сүргийн өнөр өсөлтөд шууд холбоотой байдгаас монголчууд их хайрлан арчилдаг.

Тахилга: Романы 22 дугаар бүлэгт хааны зарлигаар Алтайн зүг аялах болсон Хоролой ноён, таван зуун хүнээс бүрэлдсэн цэрэг ангидаа баруун өндөрт гарч, овоо босгон туг тахихыг зарлан газар сонгох, овоо барьж босгох, овооны өргөл өргөх зэрэг овоо тахилгын зан үйлүүдийг гүйцэтгэдэг. Романы 30 дугаар бүлэгт Хоролой ноёноос ой шугуйг хайрлан хамгаалахын бэлгэдлээр мод сэтэрлэн тахиулсан, хээрийн амьтныг дураар агнахыг цаазалсан, тэнүүлчин ардын хөрс шороо эвдэхийг хориглох, булаг ус дарсан хүнийг шийтгэж торгох гэх мэтийн байгалиа хамгаалах арга ухааныг харуулсан өгүүлэмжүүд бий.

Мэргэ төлгө: Роман дахь Шалбингийн бөхийн багш Балуд өвгөн бол сайн төлгөч юм. Романд Балуд өвгөн есөн зоосны төлгө шинжих зан үйлийг нэгэн удаа дүрслэв. Энд есөн зоосны төлгө шинжих үндсэн аргыг илрүүлсэн хэсгийг товчилж зөвхөн тооны бэлгэдлийг илэрхийлсэн өгүүлэмжийг дурдвал, “Миний энэ есөн шар зоос бол хулан жороогийн үүрэн доор гурван удаа дарсан юм. Хулгана жилтэй хүмүүнд төлгө буудаггүйгээс гадна, алдсан тэмээ, морь хаашаа хандаад, хоргос хомоол унагааж байх, гэрээс гарсан хүмүүний халуун хүйтэн ямар газарт явж сууж байхыг андалгүй мэддэг мэргэн зоос бий” (Улаанхүү 2017, 330) гэжээ. Тоо хэмжээний бэлгэдэл хийгээд төлгө шинжих зан үйлийн гүн давхаргад нь сүсэг бишрэлийн үнэт зүйл агуулагдаж байна.

Бэлэвсрэлийн ёс: Романд гол дүр Шалбин бэлэвсрэлийн ёсыг хоёр удаа гүйцэтгэсэн юм. Түүний ээж нь бурхан болоход “Дөчин ес хонотол айлд орохгүй, өнөө жилийн хувьд эхнэр авч өрх онгойлгохгүй” (Улаанхүү 2017, 566) гэжээ. Нөгөө нь Шалбингийн ахаа хэмээн хүндэлж явдаг Гилдүү нас барахад мөн хүнд гашуудан, бэлэвсрэлийн ёс гүйцэтгэв. Ингэхдээ, “Хорин нэгэн хоногийн хиншүү тавин, хүнд гашуудлыг хүүгийн ёсоор гүйцэтгэхдээ тасалдуулахгүй байхыг хичээжээ” (Улаанхүү 2017, 604) гэв. Романд илэрсэн хоёр жишээнд хорин долоо хоног буюу дөчин ес хоногийн бэлэвсрэлийн хугацааны зан үйлийг харуулсан бөгөөд гүн гүнзгий утга агуулга нь монголчуудын өвөг дээдсээ хүндэтгэн биширдэг хүндэтгэлийн үнэт зүйлийг илэрхийлнэ.

Эх хэл. Романы оршил хэсэгт зохиолч романы нэрийн утга агуулгыг онцгойлон тайлбарласан байдаг: “Үг хэл, үсэг бичиг бол эрх чөлөөний өнөд бэлгэдэл. Энэхүү бэлгэдэл бүхий төрөлх эх хэлээр зохион туурвисан энэ бүтээлийн маань амин сүнс болох тэнгэр сүлдийн товруу - мөнгөн зодог товруут бол монголын хувь заяаны гунигт дурсамж биш харин өөдлөн мандахын зөн бэлгэдэл юм”. Энэ нь тухайн бүтээл монгол хүний оюун санааны баялаг, хэл соёлын дархлааг илтгэх амин сүнсийг хадгалсан бүтээл гэдгийг илэрхийлнэ. Тус романд нутгийн аялгууны өвөрмөц үг хэллэгийг маш чадварлаг, амьд, уран дүрслэлтэй ашигласан нь зохиолын өвөрмөц шинж чанарыг улам тодруулж, түүний утга уянгын нөлөөг нэмэгдүүлсэн байна. Энэ нь зохиолд зөвхөн сайхан найруулга төдийгүй, тухайн нутгийн хэл, соёлын өвийг амьд байлгаж, хамгаалсан үнэ цэнтэй бүтээл болохыг харуулж байна. Монгол хэлний үгийн санд чухал хувь нэмэр оруулснаар тус роман нь хэл, соёлын олон ургалч байдал, түүний өв уламжлалыг улам баяжуулан хөгжүүлэхэд үнэтэй үүрэг гүйцэтгэжээ. Ийнхүү зохиол нь Алшаа хошууд монголчуудын хэл соёлын өвийг тээж, хойч үедээ уламжлуулах үнэт соёлын сан хөмрөг болсон билээ.

Мэдлэг ухаан. Нүүдэлчин ухаан бол монголчуудын эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлсийн нэг юм. Монголчуудын аж ахуйн соёл нь үндсэндээ нүүдэллэн амьдрах, мал аж ахуй эрхлэхэд суурилсан бөгөөд энэ нь тэдний амьдрал, соёл, ёс заншилд нөлөөлж ирсэн. Тус соёл нь байгаль орчны нөхцөлд тохируулан нүүдлийн мал аж ахуй, газар тариалангийн ухаан, амьдралын хэв маягийг хөгжүүлсэн арга ухаан юм. “Тэнгэр сүлд товруу” романд мянган адуунаас хүлэг илэрдэг хэмээн өгүүлж, хүлэг шинжих, Ядам өвгөн, Араантив өвгөн, Шалбин зэрэг дүрээр хүлэг арчлан маллах, морь уралдах арга ухааныг дүрсэлдэг.

Мөн монголчуудын эрдэм ухааны нэгэн илэрхийлэл болгож монгол шатрын талаар дэлгэр өгүүлдэг. Монгол шатар хүмүүсийн оюун ухаан, уран сэтгэхүйг нээн, нэмэгдүүлэх онцын үйлдэлтэй тоглоом бөгөөд газар нутгаа хамгаалахад сургах утга үүрэгтэй тоглоом билээ. Улаанхүү монгол шатрын ид шидийг өөрийн эрхгүй өргөн магтаж, “Тэнгэр сүлд товруу” романдаа Хоролой ноён, Мэргэд ба Тонтой зэрэг дүрээр зан үйл ба чанагш мэдлэг ухааны үнэт зүйлийг нь илрүүлдэг. Тухайлбал романд,

“Цэрэг морин жагсаалыг шатрын жаран дөрвөн суудал дээр дураар улируулан бодож, мянган газрын алс дахь хүчирхэг дайсныг нүдэн доор ялан дийлэх төгс итгэлийн хүчинд нэг алхмаас долоон алхмыг цагаартал шинэжин тунгааж, алхам бүрд атган тэнгэрийг чичрүүлэх гайхамшигт увдисыг зүрхний гүнд

бясалгах энэ тоглоом нь ур мэргэшил, оюун ухааны хатуу сорилт болдгоороо хүмүүний сонирхлыг татан байдаг ажгуу. Хүмүүн болгон дайны бодлоготон биш ч шатарчин болж болмуй, шатарчин бүхэн баатар биш ч дайны хөлийг төсөөлж болмуй. Шатрын хөлгөн дээр цус урсгам гунигт ялагдал бий, нулимс асгаруулам омогт ялалт ч бий. Тэр бүхнийг сэтгэлээр мэдэрч чадсан эр бүхэн энэхэн хорвоогийн өнцөг буланг алганы зураас мэт тодорхой харж эс чадсан ч билгийн тэнгэрээс оюуны хур асгаруулж болмуй за” (Улаанхүү 2017, 777) хэмээн бахдан өгүүлжээ.

Үүнийг уншихад, монголчуудын шатрыг “Сүнсгүй ноён хүнсгүй цэрэгтэй уулгүй талд цусгүй тулаан хийнэ/ Уулгүй талд усгүй цөлд засаггүй ноён цусгүй тулалдана” (Монгол хэлний их тайлбар толь. 2024.11.28) хэмээн оньсголсон байдаг нь эрхгүй санагдаж байна.

Хэлэлцүүлэг

Аливаа нийгэмд соёлыг бүтээгчийн өвөрмөц туршлага, хэтийн төлөвийг тусгасан өөрийн гэсэн тэмдэг, бэлгэдэл, үнэт зүйл, хэм хэмжээ байдаг (Золзаяа 2024, 86). Бидний судлан үзэж буй Бармуд Улаанхүүгийн “Тэнгэр сүлд товруу” роман нь Улаанхүү хэмээгч үндэсний гүн гүнзгий мэдлэгт бөгөөд бүтээлч сэтгэлгээт зохиолчийн туршлага, түүнийг өсгөн бойжуулсан Алшаа хошууд угсаатны түүх соёл, цаашлаад Монгол үндэстний соёлын үнэт зүйлсийг өргөн хүрээнд агуулсан зохиол болохын хувьд орчин цагийн олон соёлын түрэлт, басхүү найрсал дундаас “өөрсдийн үнэт зүйл”-ийг олж харах, хэтдээ соёлоо хадгалж хамгаалан, уламжлуулахад жишиг болохуйц зохиол гэдэг нь соёлын онол, арга зүйгээр задлах явцад мэдэгдэж байна. Эндээс улбаалан хэлэлцүүлэхэд, бусад зохиолчдод ч “Тэнгэр сүлд товруу” романаас үлгэр дуурайл авч, цаашид бүс нутгийн хэмжээнд соёлын ой санамжийн бүтээл туурвих, тухайн бүтээлүүдэд үнэт зүйлийн олон талт судалгаа хийх бүрэн боломж байгаа юм.

Дүгнэлт

“Тэнгэр сүлд товруу” роман нь Алшаа хошууд монголчуудын соёлын гүн гүнзгий илрэл бөгөөд биет болоод биет бус өвөө хадгалан хамгаалахад ихээхэн тулгуур болохуйц бүтээл хэмээн биднээр зогсохгүй олон судлаач үнэлээд буй. Харин монгол соёлын олон талт, баялаг илэрхийллийг цогц байдлаар судлан, онолын үүднээс задлан шинжлэхэд дараах хэдэн зүйлс тодорхой байна.

1. Романаас илрэн тодорч буй монголчуудын үнэлж хүндэлж, үнэт зүйлээ болгодог зүйл нь *мэдлэг ухаан, хүч чадал, эх хэл, сүсэг бишрэл* хэмээх дөрвөн зүйл байна. Эдгээрийг монголчууд алив сайн сайхан, эерэг үнэлэмжээр үнэлж, ахуй амьдрал, оюун санаандаа хүчтэй төсөөлж, мөрөөдөж, хамгаалж, тэмцэж оршдогийг “Тэнгэр сүлд товруу” романд бэлхнээ харуулжээ. Тийм ч учраас Хофстедийн соёлын давхраат загварын цөм хэсэгт эдгээр зүйлс оршиж байна. Дээр дурдсан дөрвөн зүйлийн үнэт зүйлийг ахуй амьдралд биежүүлэн харуулдаг *зан үйл* хэмээх нь монголчуудын хувьд ёс заншил, хэм хэмжээг нарийн баримтлах “аман хууль”-ийн шинжтэй гэдгийг “Тэнгэр сүлд товруу” романы үйл явдлуудад тодорхой тусгагджээ.

2. Аливаа үндэстэнд нандигнан хамгаалж, ижилслээ бүтээж, үлгэрлэн дуурайдаг **баатар**-ууд байдгийн нэг бол Шалбин бөх бөгөөд эх, гэр хоёроо үүрч нүүх, цээжинд нь чоно зулзагалах, арьсан тулмаар тоглож өсөх гэсэн үлгэр загваруудаар түүний “хөрөг дүр”-ийг романд бүтээжээ. Шалбин бөхийн дүр бол баатар эрсийн дүрээр үндэстний соёл, уламжлалыг хамгаалан, уламжлуулдгийн нэгэн тод томруун жишээ ажээ.
3. Соёлын илэрхийллүүдийн хамгийн гадна давхаргад **бэлгэдэл** орших бөгөөд аливаа соёл, соёлын хүнийг ойлгоход тэдгээр бэлгэдлийг юун түрүүн ойлгож харилцдаг билээ. Ийм бэлгэдэлд өнгө, тоо зэрэг орох агаад монголчуудын хувьд таван хошуу малтай холбоотой алив бэлгэдлийг ойлгохыг эл романд чухалчилжээ.
4. Соёлын давхраат загвараар авч үзэхэд, *үнэт зүйл-зан үйл-баатар-бэлгэдэл*-ийг хэлхэн холбож буй **үйлдэл** (practice) нь романы хувьд **хүүрнэл** (narrative) бөгөөд “Соёлын их хувьсгал”-ын дараах олон жилийн туршид ӨМӨЗО дахь урлаг, утга зохиолынхны өөрсдийн чиг зам, амин сүнсээ олох гэсэн тэмцлийн сүүл үеийн үр дүн болох “*соёллог хүүрнэл зохиол*”-ын тод жишээ нь “Тэнгэр сүлд товруу” роман мөн болно.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Алтан-Уул, Цорос. 2021. Шалбуур бөх. Хайлаар: Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо.

Гомбосүрэн, Ц. 2008. *Философи (Сурах бичиг)*. Улаанбаатар: МУИС-ийн Хэвлэх үйлдвэр.

Золзаяа, М. 2024. “Соёлын үнэт зүйлийн судалгаанд символик интеракционизмын үүднээс хандах нь.” *Монголын соёл урлаг судлал* 25 (49): 78-88.

Монгол хэлний их тайлбар толь. т.ү. “шатар.” 2024.11.28. <https://www.mongoltoli.mn/=шатар>

Улаанхүү, Бармуд. 2017. Тэнгэр сүлд товруу. Хөх хот: Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо.

Гадаад хэлээр:

基尔特·霍夫斯泰德.文化与组织: 心理软件的力量. Translated by 张炜, 王烁. 电子工业出版社, 2019. (Geert Hofstede. 2019. *Culture and Organization: The Power of Psychological Software*. Translated by Zhang Wei, Wang Shuo. Electronic Industry Press.)

Ярилцлага:

Бармуд Улаанхүүтэй хийсэн ярилцлага. ӨМӨЗО гэрт нь, 2024.8.1.